

НИЙСЛЭЛИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТ
(2026 оны 1 дүгээр улирал)

2026 оны 3 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нийслэлийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг дараах байдлаар зохион байгуулж ажиллаж байна.

Нэг.Өргөдөл, гомдол бүртгэл, шийдвэрлэлтийн байдал

2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 3 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар тус газарт иргэд, албан хаагчдаас нийт 54 өргөдөл, гомдол, хүсэлт ирснийг ННЗБ-ын ERP системд бүртгэн, шилжүүлэн, шийдвэрлэж ажиллалаа.


Үүнээс 31 өргөдөл, гомдол, хүсэлтийг иргэдээс ирүүлсэн байна.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хандалтын байдлаар нь авч үзвэл:

- Зах болон худалдааны төв, дэлгүүрийн худалдаа, үйлчилгээний тухай 11
- Хоолны газар, баар, рестораны үйлчилгээний тухай 4
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай 4
- Хувийн аж ахуй, фермерийн үйл ажиллагааны тухай 2
- Хүнсний чанар, аюулгүй байдлын хяналтын тухай 2
- Хөдөлмөр эрхлэлтийн тухай 2
- Боловсролын салбарын үйл ажиллагааны тухай 1
- Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны үйл ажиллагааны тухай 1
- Дүүргийн Засаг даргын бодлого, үйл ажиллагааны тухай 1
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай 1
- Ногоон бүсийн ашиглалт, хамгаалалтын тухай 1
- Ерөнхий боловсролын үйлчилгээний тухай 1

Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа мөн үед 2025 оны нэгдүгээр улиралд 9 хоног, 13 цаг, 2 минут байсан бол. 2026 оны нэгдүгээр улиралд 3 хоног, 12 цаг, 34 минут байна.

Хоёр.Өргөдөл гомдлын хандалтын харьцуулсан үзүүлэлт



2025 оны 1 дүгээр улиралд нийт 50 өргөдөл гомдол, үүнээс иргэний хандалт 44, 2026 оны 1 дүгээр улиралд нийт 54 өргөдөл гомдол, үүнээс иргэний хандалт 31 байна.

Иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод байлгах үүднээс 10 хоног тутамд явцын тэмдэглэл хөтлөн, 2-3 шат дамжлагатайгаар шийдвэрлэн, хариу өгч ажиллаж байна. Тайлант хугацаанд ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад зөрчил бүртгэгдээгүй.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА ТӨЛӨВЛӨЛТ
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.БАЯНХУТАГ

ТАЙЛАН БИЧСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН
АЖИЛТАН

Т.САЙНЖАРГАЛ